



Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГЫН ДҮНД ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

# 2014



**Баруун-Урт хот**  
**2015 он**

## АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ  
ЗУРГИЙН ЖАГСААЛТ  
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХОД АШИГЛАХ ИТГЭЛЦҮҮР  
ОРШИЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ.....	10
1.1. Мал бүхий өрх, малчид.....	11
1.2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлтүүд .....	12
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАЛЫН ТОО, БҮТЭЦ.....	13
2.1. Малын тооны өсөлт, бууралт.....	14-16
2.2. Хувийн /амины/ малын тоо.....	16-18
2.3. Хээлтэгч мал.....	18-19
2.4. Төл бойжилт.....	19-20
2.5. Том малын зүй бус хорогдол.....	20-21
2.6. Малын хээл хаялт, сувайралт.....	21-22
2.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	22
2.8. Малын хэрэглээний зарлага.....	22-23
2.9. Сүргийн бүтэц.....	23-24
2.10. Цэвэр үүлдрийн болон эрлийз мал.....	24
ГУРАВДУГААР БҮЛЭГ. МАЛЫН ТЭЖЭЭЛ .....	25-26
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЭЖЭЭВЭР АМЬТАД.....	27
ТАВДУГААР БҮЛЭГ. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	28-29
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ШИНЭЭР ГАРГАСАН БОЛОН ЗАСВАРЛАСАН ХУДГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	30-31
ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ТАРИАЛАН.....	32
7.1. Тариалсан талбай.....	33
7.2. Хураасан ургац.....	34
ДҮГНЭЛТ.....	35-36
АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ.....	36
ХАВСРАЛТ.....	37
ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	37-53

**ТАНИЛЦУУЛГА ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА**

**Т.ЭРДЭНЭБАТ**

**ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН: МЭРГЭЖИЛТЭН**

**Э.АНХЦЭЦЭГ**



САНАЛ ХУСЭЛТ БАЙВАЛ ДООРХ

ХАЯГААР ХОЛБОО БАРИНА УУ.

**СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

Монгол улс, Сүхбаатар аймаг

Баруун-Урт сум, 7-р баг

Аймгийн нутгийн удирдлагын ордон

Өрөө: 103 тоот

Утас: 70518203, 98711185

И-мэйл: [sukhbaatar@nso.mn](mailto:sukhbaatar@nso.mn)

Интернет хаяг: [web.nso.mn/portal/sukhbaatar](http://web.nso.mn/portal/sukhbaatar)

[www.facebook.com/statistic](http://www.facebook.com/statistic)

Баруун-Урт сум

2015 он

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Өрх, малчдын тоо, насны бүтэц.....	13
Хүснэгт 1.2.1. Малчин өрхийн нийгэм ахуйн үзүүлэлтүүд.....	14
Хүснэгт 1.2.2. Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо.....	14
Хүснэгт 2.1.1. Малын тоо, төрлөөр.....	15
Хүснэгт 2.1.2. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь.....	15
Хүснэгт 2.2.1. Хувийн малын тоо.....	17
Хүснэгт 2.2.2. Малтай өрхийн малын бүлэглэлт.....	17
Хүснэгт 2.2.3. Малтай нэг өрхөд ноогдох малын тоо, бүлэглэлтээр.....	18
Хүснэгт 2.3. Хээлтэгч малын тоо.....	18
Хүснэгт 2.4.1. Төл бойжилт.....	19
Хүснэгт 2.4.2. 100 эхээс бойжуулсан төл.....	20
Хүснэгт 2.5.1. Том малын зүй бус хорогдол.....	21
Хүснэгт 2.5.2. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо.....	21
Хүснэгт 2.6. Хээл хаяж, сувайрсан малын тоо.....	22
Хүснэгт 2.7.1. Хээлтүүлэгч малын тоо.....	22
Хүснэгт 2.7.2. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	22
Хүснэгт 2.8.1. Малын хэрэглээний зарлага.....	23
Хүснэгт 2.8.2. Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо.....	23
Хүснэгт 2.9. Сүргийн бүтэц.....	24
Хүснэгт 2.10. Цэвэр үүлдрийн болон эрлийз мал.....	24
Хүснэгт 5.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо, ам бүлээр.....	25
Хүснэгт 5.2. Малжуулах арга хэмжээгээр олгогдсон малын тоо.....	26
Хүснэгт 5.3. Малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн тайлан.....	26
Хүснэгт 6.1.1. Шинээр гаргасан худгийн тоо.....	26
Хүснэгт 6.1.2. Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө.....	27
Хүснэгт 6.2.1. Засварласан худгийн тоо.....	27
Хүснэгт 6.2.2. Худаг засварлахад зарцуулсан хөрөнгө.....	27
Хүснэгт 7.1. Тариалсан талбай, га-гаар.....	29
Хүснэгт 7.2. Хураасан ургац, тн-оор .....	30

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Малчдын тоо, мян.хүн.....	12
Зураг 1.2. Малчин өрхийн нийгэм, ахуйн үзүүлэлтүүд, мян.өрх.....	14
Зураг 2.1.1. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь.....	16
Зураг 2.1.2. Малын тоо, сумаар, мян.тол.....	16
Зураг 2.1.3. Малын тоо, аймгаар, мян.тол.....	16
Зураг 2.3. Хээлтэгч малын тоо, мян.тол.....	19
Зураг 2.4.1. Бойжуулсан төлийн тоо, мян.тол.....	19
Зураг 2.4.2. 100 эхээс бойжуулсан төл.....	20
Зураг 2.5. Том малын зүй бус хорогдол, мян.тол.....	21
Зураг 2.9. Сүргийн бүтэц, 2013 он.....	24
Зураг 3.1. Бэлтгэсэн хадлан, тн.....	25
Зураг 7.1. Төмс, хүнсний ногооны тариалсан талбай, га.....	29
Зураг 7.2. Хураасан ургац, тн.....	30

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх:** Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

**Малчин өрх:** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

**Малчид:** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

**Нас гүйцсэн мал:** Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

**Өсвөр насны мал:**

Тэмээ - Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу - Өмнөх оны төл, 2 настай

Үхэр - Өмнөх оны төл

**Төл мал:** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

**Малын тоо, толгойн өсөлт:** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал нь** төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

**Төллөлтийн хувь:** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

**Бойжилтын хувь:** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

**100 эхээс бойжуулсан төл:** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Том малын зүй бус хорогдолд** өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна. **Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь:** Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Малын хэрэглээний зарлага:** Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

**Малын хашааны хангамж:** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

**Тэжээл хангамж:** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

**Малын тэжээлийн ангилал:** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
  2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

**Тариалангийн талбай:** Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**Тариалсан талбай:** Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Хураасан талбай:** Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Га-гийн ургац:** Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

**Нийт ургац:** Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

**Эдийн засгийн бүс:**

Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл

Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул

Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар

Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХОД АШИГЛАХ ИТГЭЛЦҮҮР

**Бодод шилжүүлэх коэффициент:**

1 адуу, үхэр	=	1 бод
1 тэмээ	=	1.5 бод
6 хонь	=	1 бод
8 ямаа	=	1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

**Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:**

1 тэмээ	=	5 хонь
1 адуу	=	7 хонь
1 үхэр	=	6 хонь
1 хонь	=	1 хонь
1 ямаа	=	0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур	=	20
Азарга	=	10
Бух	=	25
Хуц, ухна	=	50

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:

Хадлан өвс	=	0.45
Таримал тэжээл	=	0.35
Даршны ургамал	=	0.25
Гар тэжээл, хужир шүү	=	1.00
Төмс ногооны хаягдал	=	0.22
Үр тарианы хаягдал	=	0.90
Лай	=	0.40
Сүрэл	=	0.25

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж, тэжээлийн хангамжийг гаргана.

Тариалсан талбайг га-д шилжүүлэх итгэлцүүр

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1га

Хураасан ургацыг хэмжих нэгж

1 кг	=	1000 грамм
1000 кг	=	1 тн
100 кг	=	1 центнер
1 тн	=	10 центнер
1000000 гр	=	1 тн

Нэг га-гийн ургацын норм

Төмс	=	120 центнер
Буудай	=	11 центнер

Хүнсний ногоо

Сонгино	=	80 центнер
Лууван	=	70-80 центнер
Манжин	=	80 центнер
Байцаа	=	230 центнер

Жимс, жимсгэнэ

Чацаргана	=	бутнаас 3кг
Үхрийн нүд	=	бутнаас 800-1200 г

## ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

“Монгол улсын үндсэн хууль”-нд “мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нэгтгэн тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 7-р зүйлийн 1 дэх заалт, Монгол улсын засгийн газрын 2003 оны 224-р тогтоол, аймгийн ИТХ-ын 67 тоот тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Үндэсний Статистикийн хорооноос мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах албан бичгийн дагуу мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2014 оны 12-р сарын 7-оос 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж явуулсан.

2008 оноос манай аймагт малын индексжүүлсэн даатгалын төсөл хэрэгжиж 7 дахь жилдээ хагас, бүтэн жилээр малтай өрхийн картыг шивж тооллогын дүнг цахимаар тушааж хэвшээд байна.

Малын 2014 оны тооллогыг уламжлалт маягт, зааврын дагуу явуулж, өрх нэг бүрээр онлайнд шивж, үр дүнг нэгтгэн гаргаж аймгийн удирдлагуудад танилцуулан ҮСХ-нд хүргүүлсэн.

Энэхүү танилцуулгад малын 2014 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ болон шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаар тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ**

### 1.1. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧИД

Аймгийн хэмжээгээр 2014 оны мал тооллогын дүнгээр мал бүхий 9.3 мянган өрх тоологдсон байна. Үүний 70.3 хувь болох 6.6 мянган өрх нь жилийн 4 улиралд малаа маллаж, ашиг шимийг авч, амжиргааны эх үүсвэр болгож буй малчин өрх байгаа бол 29.7 хувь буюу 2.7 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй малтай өрх байна.

2014 оны мал тооллогын дүнгээр 13.9 мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа бөгөөд насны бүлгээр авч үзвэл 42.7 хувь нь 16-34 насны, 51.8 хувь нь 35-аас дээш тэтгэвэрт гарах хүртлэх насныхан, 5.5 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

#### ХҮСНЭГТ 1.1. ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮТЭЦ


	2009	2010	2011	2012	2013	2014
1.Малтай өрх	9 075	9 126	9 130	9 209	9 162	9314**
2.Малчин өрх	7 057	6 909	6 834	6 530	6 466	6 552
3.Малчдын тоо	15 973	15 142	14 921	13988*	13742*	13868*
үүнээс: -16-34 насны	8 301	7 293	7 061	6459*	5960*	5924*
-эмэгтэй 35-55, эрэгтэй 35-60 насны	6 292	6 557	6 601	6 658	6 920	7 182
-Тэтгэврийн насны	1 380	1 292	1 259	871	862	762
4.Нийт малчдаас эмэгтэй	7 148	6 725	6 825	6 399	6 285	6 283
5.Насны бүтэц %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
үүнээс: -16-34 насны	52.0	48.2	47.3	46.2	43.4	42.7
-эмэгтэй 35-55, эрэгтэй 35-60 насны	39.4	43.3	44.2	47.6	50.4	51.8
-Тэтгэврийн насны	8.6	8.5	8.4	6.2	6.3	5.5

Тайлбар: \* 2012 оноос малчдын тоог 15 ба түүнээс дээш насны ангиллаар гаргадаг арга зүйд шилжүүлсэн.

\*\* 2014 оноос шинэ арга зүйд шилжиж, малтай өрхийн тоонд тавиул малтай өрх ордог болсон.

Энэ оны малтай өрхийн тоог урьд онтой харьцуулахад 1.7 хувь буюу 152 өрхөөр, малчин өрх нь 1.3 хувь буюу 86 өрхөөр тус тус өссөн байна. Харин 2009 онтой харьцуулахад малтай өрх нь 239 өрхөөр, малчин өрх нь 505 өрхөөр тус тус буурчээ.

#### ЗУРАГ 1.1. МАЛЧДЫН ТОО, мян.хүн




## 1.2. МАЛЧДЫН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2014 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 90.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 79.2 хувь нь телевизортой, 43.4 хувь нь автомашинтай, 0.8 хувь нь трактортой, 52.8 хувь нь мотоцикльтэй гэсэн дүн гарлаа.

### ХҮСНЭГТ 1.2.1. МАЛЧИН ӨРХИЙН НИЙГЭМ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Өрхийн тоо					Малчин өрхийн тоонд эзлэх хувь			
	2010	2011	2012	2013	2014	2010	2012	2013	2014
Цахилгаан үүсгүүртэй	5 370	6 084	5 028	5 999	5 910	77.7	77.0	92.8	90.2
Телевизортой	4 418	5 493	4 361	5 080	5 191	63.9	66.8	78.6	79.2
Авто машинтай	1 701	1 997	2 321	2 605	2 842	24.6	35.5	40.3	43.4
Трактортой	36	37	56	57	51	0.5	0.9	0.9	0.8
Мотоцикльтэй	2 694	3 374	3 198	3 242	3 462	39.0	49.0	50.1	52.8

ЗУРАГ 1.2. МАЛЧИН ӨРХИЙН НИЙГЭМ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мян.өрх



Малчин өрхийн 92.8 хувь нь цахилгаан үүсгүүртэй байгааг төрлөөр задлавал: нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 98.9 хувь нь нарны, 1.0 хувь нь салхины, 0.9 хувь нь бусад (бага оврын мотор, аккумулятор гэх мэт) төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байна.

### ХҮСНЭГТ 1.2.2. ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРТЭЙ ӨРХИЙН ТОО

Он	Бүгд	Үүнээс:			Дүнд эзлэх хувь		
		Нарны	Салхины	Бусад	Нарны	Салхины	Бусад
2010	5 370	4 507	579	284	83.9	10.8	5.3
2011	6 084	5 391	520	173	88.6	8.5	2.8
2012	5 028	4 708	287	33	93.6	5.7	0.7
2013	5 999	5 573	282	144	92.9	4.7	2.4
2014	5 910	5 843	62	54	98.9	1.0	0.9

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **МАЛЫН ТОО, БҮТЭЦ**

## 2.1. МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, БУУРАЛТ

2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2818.2 мянган толгойд хүрч, урьд оноос 326.8 мянган толгой малаар буюу 13.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Таван төрлөөрөө авч үзвэл тэмээ 8.6 мянга, адуу 231.2 мянга, үхэр 195.9 мянга, хонь 1380.8 мянга, ямаа 1001.7 мянган толгойд тус тус хүрч, урьд онохоос тэмээ 332 толгойгоор буурсан хэдий ч адуу 28.2 мянга, үхэр 23.9 мянга, хонь 164.2 мянга, ямаа 110.9 мянган толгойгоор тус тус өсчээ. Харин таван төрлөөр сүүлийн таван жилээр авч үзвэл тэмээнээс бусад 4 төрөл дээрээ өссөн байна.

### ХҮСНЭГТ 2.1.1. МАЛЫН ТОО, төрлөөр

	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
						Хувь	Зөрүү
Бүгд	1 979 791	2 081 404	2 280 581	2 491 423	2 818 181	113.1	326 758
Тэмээ	10 867	10 678	9 752	8 903	8 571	96.3	- 332
Адуу	148 089	164 866	183 569	203 050	231 248	113.9	28 198
Үхэр	127 960	136 654	151 132	172 033	195 893	113.9	23 860
Хонь	961 223	991 975	1 090 831	1 216 623	1 380 781	113.5	164 158
Ямаа	731 652	777 231	845 297	890 814	1 001 688	112.4	110 874
Бодод шилжүүлсэнээр / мян.тол /	544.0	580.0	636.8	702.6	795.3	113.2	93

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ 0.3, адуу 8.2, үхэр 7.0, хонь 49.0, ямаа 35.5 хувийг тус тус эзэлж байна. 2013 онтой харьцуулахад нийт мал сүрэгт үхэр сүргийн эзлэх хувийн жин 0.1 пункт, хонин сүргийн эзлэх хувийн жин 0.2 пункт тус тус өсч, тэмээ сүргийн эзлэх хувийн жин 0.1 пункт, ямаан сүргийн эзлэх хувийн жин 0.2 пунктээр тус тус буурлаа. Адуун сүргийн эзлэх хувийн жин өмнө онтой адил түвшинд байна.


### ХҮСНЭГТ 2.1.2. НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Он	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2010	100.0	0.5	7.5	6.5	48.5	37.0
2011	100.0	0.5	7.9	6.6	47.7	37.3
2012	100.0	0.4	8.1	6.6	47.8	37.1
2013	100.0	0.4	8.2	6.9	48.8	35.7
2014	100.0	0.3	8.2	7.0	49.0	35.5

Сүргийн бүтцийн хувьд бог малын 75.0 орчим хувийг хонь, 25.0 орчим хувийг ямаан сүрэг эзлэх нь бэлчээрийн зохистой харьцаа болж байдаг. Харин бог малд хонин сүргийн эзлэх хувь урьд оноос 0.3 пунктээр, 2010 оноос 1.3 пунктээр тус тус

өсчээ. Гэсэн ч сүргийн бүтэц болон бэлчээрийн зохистой харьцаа алдагдсан хэвээр байна.


ЗУРАГ 2.1.1. НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Мал тооллогын 2014 оны дүнгээр Баяндэлгэр, Наран, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Баруун-Урт сумд малаа 5 төрөл дээр, бусад сумд 4 төрөл дээрээ малаа өсгөсөн байна. Харин 2013 оны байдлаар зөвхөн Сүхбаатар сум малаа 5-н төрөл дээрээ өсгөжээ.


2014 оны мал тооллогын дүнгээрээ аймагтаа нийт мал болон үхэр, хонь, ямаагаар Баяндэлгэр сум, тэмээгээр Түвшинширээ сум, адуугаар Эрдэнэцагаан сум тус тус тэргүүлж байна.

ЗУРАГ 2.1.2. МАЛЫН ТОО, сумаар, мян.тол



Улсын хэмжээнд 21 аймгийн дотор бүх малаараа 9-рт, тэмээгээрээ 9-рт, адуугаараа 5-рт, үхрээрээ 7-рт, хониороо 8-рт, ямаагаараа 13-рт тус тус орж байна.

ЗУРАГ 2.1.3. МАЛЫН ТОО, аймгаар, мян.тол



## 2.2. ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН ТОО

Хувийн малын тоо 2014 онд 2794.9 мянга болж, нийт малын 99.2 хувийг эзэлж байна. Үүний дотор тэмээний 99.3 хувь, адууны 99.3 хувь, үхрийн 99.5 хувь, хонины 99.0 хувь, ямааны 99.3 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн мал урьд оноос 320.3 мянга буюу 13.0 хувиар өссөн нь нийт малд хувийн малын эзлэх хувь өссөөр байна.

ХҮСНЭГТ 2.2.1. ХУВИЙН МАЛЫН ТОО

Төрөл	2010	2011	2012	2013	2014
Бүгд	1 957 951	2 054 642	2 255 407	2 468 200	2 794 987
Тэмээ	10 837	10 581	9 692	8 832	8 507
Адуу	146 528	163 238	181 998	201 414	229 529
Үхэр	126 950	135 484	150 146	170 941	194 856
Хонь	948 109	976 235	1 075 489	1 202 738	1 366 942
Ямаа	725 527	769 104	838 082	884 275	995 153

2014 оны байдлаар хувийн нийт малын 48.9 хувийг хонь, 35.6 хувийг ямаа, 8.2 хувийг адуу, 7.0 хувийг үхэр, 0.3 хувийг тэмээ эзэлж байна. 2010 онтой харьцуулах хувийн малын тоо 42.7 хувиар өсчээ. Харин 5-н төрлөөр нь авч үзвэл тэмээнээс бусад төрөл дээрээ өссөн байна.

Мал бүхий 9.3 мянган өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл 2014 онд 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 2857 болж, урьд оныхоос 547 өрхөөр буурсан боловч 100-гаас дээш малтай өрхийн тоо 6457 болж, урьд оныхоос 430 өрх буюу 7.1 хувиар өслөө.

2014 оны байдлаар малтай өрхийн 56.6 хувь нь 200 хүртэл толгой малтай байна. 200 хүртэл толгой малтай өрхийн тоог сүүлийн дөрвөн жилээр авч үзвэл жил болгон буурч байна.

ХҮСНЭГТ 2.2.2. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Бүлэг	Малтай өрхийн тоо				Дүнд эрлэх хувь				Малын тоо			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2013	2011	2012	2013	2014
Дүн	9 130	9 209	9 162	9 314	100.0	100.0	100.0	100.0	2 054 642	2 255 407	2 468 200	2 794 987
<10	536	533	473	409	5.9	5.8	5.2	4.4	2 962	2 977	2 787	2 438
11-30	887	835	782	685	9.7	9.1	8.5	7.4	18 311	17 158	16 015	14 006
31-50	707	673	637	581	7.7	7.3	7.0	6.2	28 677	26 940	25 620	23 445
51-100	1 492	1 363	1 243	1 182	16.3	14.8	13.6	12.7	111 005	101 398	92 404	88 175
101-200	2 023	1 991	1 920	1 927	22.2	21.6	21.0	20.7	297 986	293 481	282 519	284 748
201-500	2 437	2 596	2 677	2 810	26.7	28.2	29.2	30.2	763 544	820 861	860 362	916 838
501-999	822	934	1 048	1 228	9.0	10.1	11.4	13.2	548 819	632 696	704 967	826 308
1000-1499	192	238	324	407	2.1	2.6	3.5	4.4	220 196	272 980	372 898	473 443
1500-2000	21	34	40	60	0.2	0.4	0.4	0.6	34 042	57 078	66 789	100 139
2001+	13	12	18	25	0.1	0.1	0.2	0.3	29 100	29 838	43 839	65 447

2014 онд 1000 ба түүнээс дээш малтай 492 өрх тоологдсон нь урьд оныхоос 110 өрхөөр, 2010 оныхоос 266 өрхөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2.2.3. МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НООГДОХ МАЛЫН ТОО, бүлэглэлтээр

Бүлэг	1 өрхөд ноогдох мал				Үүнээс:				
	2011	2012	2013	2014	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	225	245	269	300	1	25	21	147	107
<10	6	6	6	6	0	2	3	0	1
11-30	21	21	20	20	0	4	5	4	7
31-50	41	40	38	41	0	7	6	9	18
51-100	74	74	74	75	0	9	8	24	34
101-200	147	147	147	148	1	15	12	55	65
201-500	313	316	321	327	1	26	22	151	128
501-999	668	677	673	674	2	47	42	357	225
1000-1499	1 147	1 147	1 151	1 167	5	87	73	665	337
1500-2000	1 621	1 679	1 670	1 669	8	168	98	921	473
2001+	2 238	2 487	2 436	2 618	8	259	151	1 580	619

Аймгийн дундажаар хувийн малтай нэг өрхөд 300 толгой мал ногдож байгаа нь урьд оноос 31 толгой малаар өслөө. Малтай нэг өрхөд тэмээ 1, адуу 25, үхэр 21, хонь 147, ямаа 107 ногдож байна. 1 өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 84.3 хувь нь бог мал, 15.7 хувь нь бод мал байна. Сүүлийн 4-н жилийн хугацаанд нэг өрхөд ноогдох малын тоо өсчээ.

2.3. ХЭЭЛТЭГЧ МАЛ

Хээлтэгч мал 2014 оны эцэст 1219.8 мянган толгой тоологдсон нь урьд оныхоос 130.7 мянган толгой буюу 12.0 хувиар өссөн байна.


Төрлөөр нь авч үзбэл ингэ 2.9 мянга толгойгоор буурч бусад 4 төрөл дээрээ өссөн бөгөөд гүү 8.5 мянга, үнээ 8.7 мянга, эм хонь 68.9 мянга, эм ямаа 44.7 мянгаар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2.3. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Төрөл	2010	2011	2012	2013	2014	2013/2012	
						Хувь	Зөрүү
Бүгд	858 681	903 554	994 105	1 089 143	1 219 828	112.0	130 685
Ингэ	3 798	3 718	3 522	3 389	3 290	97.1	- 99
Гүү	43 243	48 029	53 775	60 439	68 913	114.0	8 474
Үнээ	48 751	53 159	58 983	66 069	74 802	113.2	8 733
Эм хонь	438 648	454 780	500 462	559 973	628 851	112.3	68 878
Эм ямаа	324 241	343 868	377 363	399 273	443 972	111.2	44 699

Хээлтэгч мал нийт малын 43.3 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 38.4 хувь, адуун сүргийн 29.8 хувь, үхэр сүргийн 38.2 хувь, хонин сүргийн 45.5 хувь, ямаан сүргийн 44.3 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2.3. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, мян.тол



## 2.4. ТӨЛ БОЙЖИЛТ

2014 онд оны эхний хээлтэгч малын 86.1 хувь буюу 938.0 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.1 хувь буюу 937.0 мянган төл бойжууллаа. Бойжсон төлийн тоо урьд онохоос 83.7 мянган толгойгоор өсч, бойжилтын хувь 0.7 пунктээр өсчээ.


Гарсан төлөөс бойжилтын хувийг 5 төрлөөр авч үзвэл ботгоны 96.7 хувь, унаганы 99.5 хувь, тугалын 99.4 хувь, хурганы 99.1 хувь, ишигний 98.9 хувийг тус тус бойжуулаад байна.

ХҮСНЭГТ 2.4.1. ТӨЛ БОЙЖИЛТ

	Бүгд				Үүнээс:				
	2011	2012	2013	2014	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	757 391	795 225	867 458	945 730	1 535	49 276	54 597	487 850	352 472
Бойжсон төл	744 656	786 098	853 262	937 037	1 484	49 015	54 290	483 603	348 645
Бойжилтын хувь	98.3	98.9	98.4	99.1	96.7	99.5	99.4	99.1	98.9

2014 онд бойжуулсан төлийн тоог сумдаар авч үзвэл Асгат, Дарьгангаас бусад сумд 0.2-20.0 мянган толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 2.4.1. БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО, мян.тол




Аймгийн дунджаар 2014 онд 100 эхээс 86 төл бойжуулсан нь урьд оноос 8-н төлөөр буюу 10.3 хувиар өсөөд байна.

ХҮСНЭГТ 2.4.2. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	85	87	87	78	86
Ботго	48	44	47	44	44
Унага	76	80	82	67	81
Тугал	88	84	86	72	82
Хурга	86	88	89	79	86
Ишиг	84	87	86	81	87

ЗУРАГ 2.4.2. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ



2.5. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2014 онд оны эхний нийт малын 0.4 хувь болох 10.8 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оныхоос 15.2 мянган толгой малаар буурчээ. Нийт хорогдсон малын 35.8 хувийг ямаа, 33.2 хувийг хонь, 26.6 хувийг үхэр, 4.1 хувийг адуу, 0.3 хувийг тэмээ эзэлж байна.


ХҮСНЭГТ 2.5.1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Төрөл	2010	2011	2012	2013	2014	Оны эхний малд эзлэх хувь				
						2010	2011	2012	2013	2014
Бүгд	60 930	54 654	20 915	25 971	10 779	3.4	2.8	1.0	1.1	0.4
Тэмээ	129	124	85	99	39	1.3	1.1	0.8	1.0	0.4
Адуу	1 818	1 731	753	977	437	1.4	1.2	0.5	0.5	0.2
Үхэр	6 722	4 214	1 140	1 641	2 870	6.1	3.3	0.8	1.1	1.7
Хонь	26 978	23 022	8 847	11 066	3 574	3.2	2.4	0.9	1.0	0.3
Ямаа	25 283	25 563	10 090	12 188	3 859	3.7	3.5	1.3	1.4	0.4

Том малын зүй бус хорогдлыг урьд онтой харьцуулахад Дарьганга 70, Мөнххаан 728, Наран 189, Онгон 83, Түвшинширээ 1750 толгой малаар өсчээ.

Сүүлийн 11-н жилийн хугацааны том малын зүй бусын хорогдолыг харахад 2008 онд 387.9 мянган толгой мал хорогдсон нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 2.5. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, мян.тол



Нийт хорогдлоос 1.0 хувь буюу 109 толгой мал гэнэтийн аюулаар, 28.6 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо урьд оноос 6.7 мянган толгойгоор дээгүүр гүйцэтгэлтэй байна.

ХҮСНЭГТ 2.5.2. ГЭНЭТИЙН АЮУЛААР ХОРОГДСОН МАЛЫН ТОО

Төрөл	2010	2011	2012	2013	2014
Бүгд	7 947	6 062	2 218	6 797	109
Тэмээ	14	1	8	21	2
Адуу	302	16	47	186	74
Үхэр	391	339	91	354	27
Хонь	3 899	3 024	1 126	3 177	6
Ямаа	3 341	2 682	946	3 059	-

## 2.6. МАЛЫН ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ

2014 онд оны эхний хээлтэгч малын 8.3 хувь болох 89.9 мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна.

Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо урд оныхоос 0.8 хувь буюу 715 толгой малаар өсчээ.

Төл өгөөгүй хээлтэгч малын 85.8 хувь буюу 77.2 мянган толгой мал нь сувайрсан, 14.2 хувь буюу 12.8 мянган толгой мал нь хээл хаясан эх мал байна.

## ХҮСНЭГТ 2.6. ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН МАЛЫН ТОО

Төрөл	Сувайрсан					Хээл хаясан				
	2010	2011	2012	2013	2014	2010	2011	2012	2013	2014
Бүгд	41 026	47 578	54 286	74 947	77 206	13 019	13 688	12 961	14 335	12 791
Ингэ	117	178	165	137	99	15	19	15	24	12
Гүү	5 038	5 445	5 757	9 213	7 553	1 005	1 044	799	1 209	675
Үнээ	3 345	4 328	5 195	9 512	8 022	749	989	793	911	768
Эм хонь	17 385	19 969	22 457	31 316	33 937	5 830	5 963	5 452	5 436	5 734
Эм ямаа	15 141	17 658	20 712	24 769	27 595	5 420	5 673	5 902	6 755	5 602

## 2.7. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО:

2014 онд 26.1 мянган хээлтүүлэгч мал тоологдож, урьд оныхоос 2.4 мянган толгойгоор буюу 10.4 хувиар өссөн байна.

## ХҮСНЭГТ 2.7.1. ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

Төрөл	2010	2011	2012	2013	2014
Бүгд	19 192	21 136	22 166	23 667	26 117
Буур	147	138	149	118	106
Азарга	6 866	7 514	7 926	8 653	9 389
Бух	1 471	1 573	1 671	1 798	1 890
Хуц	6 436	7 116	7 236	7 905	8 858
Ухна	4 272	4 795	5 184	5 193	5 874

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь тэмээ, адууны хувьд үржлийн нормоороо, харин үхэр, хонь, ямаа зэргийн үржлийн норм алдагдсаар байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50 хээлтэгч ногдох ёстой атал 2014 онд аймгийн дунджаар 71 эм хонь, 76 эм ямаа ногдож байгаа нь 42-52 хувиар өндөр үзүүлэлтэй байна.

## ХҮСНЭГТ 2.7.2. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО

Төрөл	Үржлийн норм	2010	2011	2012	2013	2014
Буур	20	26	27	24	29	31
Азарга	10	6	6	7	7	7
Бух	25	33	34	35	37	40
Хуц	50	68	64	69	71	71
Ухна	50	76	72	73	77	76

## 2.8. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

2014 онд оны эхний малын 22.9 хувьтай тэнцэх 570.8 мян.толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага урьд оныхоос 20.2 мянган толгойгоор өссөн байна.

Малтай нэг өрх дунджаар 61 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан нь урьд онтой харьцуулвал 1 толгой малаар өссөн байна.

ХҮСНЭГТ 2.8.1. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Төрөл	2010	2011	2012	2013	2014	Оны эхний малд эзлэх хувь				
						2010	2011	2012	2013	2014
Бүгд	405 184	588 389	566 006	550 647	570 775	22.6	29.7	27.2	24.1	22.9
Тэмээ	859	1 736	2 593	2 096	1 739	8.5	16.0	24.3	21.5	19.5
Адуу	11 536	15 955	19 861	25 572	20 720	8.8	10.8	12.0	13.9	10.2
Үхэр	13 834	27 807	30 283	31 945	31 235	12.6	21.7	22.2	21.1	18.2
Хонь	200 555	332 372	294 956	274 760	303 965	23.5	34.6	29.7	25.2	24.9
Ямаа	178 400	210 519	218 313	216 274	213 116	26.1	28.8	28.1	25.6	23.9

Оны эхний бүх малын 22.9 хувь, тэмээний 19.5 хувь, адууны 10.2 хувь, үхрийн 18.2 хувь, хонины 24.9 хувь, ямааны 23.9 хувийг тус тус хэрэглээнд зарцуулжээ.

Хэрэглээнд зарцуулсан малын 90.6 хувийг бог мал, 9.4 хувийг бод мал эзлэж байна.

ХҮСНЭГТ 2.8.2. ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАН БОРЛУУЛСАН БОЛОН АЖ АХУЙН ДОТООДОД ХЭРЭГЛЭСЭН МАЛЫН ТОО

Төрөл	Зах зээлд худалдан борлуулсан					Аж ахуйн дотоодод хэрэглэсэн				
	2010	2011	2012	2013	2014	2010	2011	2012	2013	2014
Бүгд	198.1	284.2	287.1	330.3	374.0	94.6	105.6	106.2	112.2	113.2
Тэмээ	0.6	1.1	1.3	1.5	1.3	0.1	0.1	0.0	0.1	0.0
Адуу	8.9	10.9	12.0	13.9	16.3	5.4	5.7	6.0	5.5	5.5
Үхэр	9.5	15.8	17.3	18.4	22.7	6.6	7.7	8.3	7.8	8.1
Хонь	99.7	156.3	149.5	167.0	196.4	42.8	51.5	49.6	53.7	55.5
Ямаа	79.4	100.1	107.0	129.5	137.3	39.7	40.6	42.3	45.2	44.1

Хэрэглээнд зарцуулсан малын 65.5 хувийг зах зээлд худалдан борлуулж, 19.8 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулсан байна.

Малтай нэг өрх дунджаар 40 толгой малыг зах зээлд борлуулж, 12 толгой малыг өрхийн хэрэглээндээ зарцуулсан байна.

2.9. СҮРГИЙН БҮТЭЦ


Нийт сүргийн бүтцийг 2014 оны байдлаар авч үзэхэд 35.6 хувь буюу 1003.2 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 20.2 хувь буюу 569.1 мянган толгой нь ажлын ба бэлтгэлийн насны эр мал, 43.7 хувь буюу 1089.1 мянган толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 23.7 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

ХҮСНЭГТ 2.9. СҮРГИЙН БҮТЭЦ

	мян.тол				Хувиар				2014/2013	
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014	Хувь	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>2 081.4</b>	<b>2 280.6</b>	<b>2 491.4</b>	<b>2 818.2</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>113.1</b>	<b>326.8</b>
Төл, өсвөр насны мал	744.5	824.9	893.6	1 003.2	35.8	36.2	35.9	35.6	112.3	109.6
Ажлын ба бэлтгэлийн насны эр	412.2	439.4	485.0	569.1	19.8	19.3	19.5	20.2	117.3	84.1
Хээлтэгч	903.6	994.1	1 089.1	1 219.8	43.4	43.6	43.7	43.3	112.0	130.7
Хээлтүүлэгч	21.1	22.2	23.7	26.1	1.0	1.0	0.9	0.9	110.1	2.4

Малын сүрэгт эзлэх хувийг насаар нь урьд оныхтой харьцуулахад ажлын ба бэлтгэлийн насны эр мал 0.7 пунктээр өсч, төл, өсвөр насны мал 0.3 пункт, хээлтэгч 0.4 пунктээр тус тус буураад байна. Харин хээлтүүлэгч мал нь урьд оны мөн үетэй адил түвшинд байна.

ЗУРАГ 2.9.СҮРГИЙН БҮТЭЦ, 2014 он



2.10. ЦЭВЭР ҮҮЛДРИЙН БОЛОН ЭРЛИЙЗ МАЛ

2014 оны эцэст цэвэр үүлдрийн 1020.6 мянган толгой, эрлийз 413.5 мянган толгой мал тус тус тоологдов. Урьд онтой харьцуулахад цэвэр үүлдрийн малын тоо 620.1 мянган толгойгоор өсч, эрлийз малын тоо 195.9 мянган толгойгоор буурсан байна.

ХҮСНЭГТ 2.10. ЦЭВЭР ҮҮЛДРИЙН БОЛОН ЭРЛИЙЗ МАЛ

	Цэвэр үүлдэр				Эрлийз			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014
<b>Бүгд</b>	<b>269 766</b>	<b>403 285</b>	<b>400 500</b>	<b>1 020 610</b>	<b>785 663</b>	<b>422 833</b>	<b>609 396</b>	<b>413 485</b>
Тэмээ	125	830	687	621	-	-	-	-
Адуу	146	140	20 742	25 351	769	-	-	-
Үхэр	5 159	3 532	3 992	16 585	15 992	14 880	18 161	9 658
Хонь	82 578	94 506	153 074	469 018	400 951	309 422	376 330	292 341
Ямаа	181 758	304 277	222 005	509 393	367 951	98 531	214 905	111 486

## ГУРАВДУГААР БҮЛЭГ


### МАЛЫН ТЭЖЭЭЛ

Аймгийн хэмжээгээр 2014 онд 12.9 мянган тн байгалийн хадлан, 250.5 мянган тн гар тэжээл бэлтгэсэн байна.

Урьд онтой харьцуулвал байгалийн хадлан 7.8 хувиар өсч, гар тэжээл 61.9 хувиар буурчээ.

Харин урьд онд байсан таримал тэжээл, төмс, хүнсний ногооны хаягдалыг бэлтгээгүй байна.

ЗУРАГ 3.1. БЭЛТГЭСЭН ХАДЛАН, тн



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЭЖЭЭВЭР АМЬТАД

Аймгийн хэмжээгээр 2014 оны эцэст 191 гахай, үүний 85 нь мэгж, 1201 шувуу, үүний 1158 нь өндөглөгч, 29 зөгийн бүл тоологдсон байна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

**МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ  
МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээг авч, нилээд хөрөнгө, мөнгийг зарцуулж байна.

### ХҮСНЭГТ 5.1. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН ӨРХИЙН ТОО, ам бүлээр

	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан								1 өрхийн ам бүлийн тоо			
	Өрхийн тоо				Ам бүлийн тоо				2011	2012	2013	2014
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014				
Дүн	284	254	157	159	1 119	1 012	595	581	4.0	4.0	4.0	4.0

Аймгийн хэмжээнд 2014 оны байдлаар 159 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо дундажаар 4 байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо урьд оныхоос 2 өрхөөр өсчээ.

### ХҮСНЭГТ 5.2. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГЭЭР ОЛГОГДСОН МАЛЫН ТОО

	Малжуулалтаар авсан малын тоо, тол			Үүнээс			Малжуулалтаар авсан малд эзлэх хувь		Малжуулалтанд хамрагдсан 1 өрхөд ноогдох малын тоо					
	2012	2013	2014	Бод малын тоо			Бог малын тоо		Бод мал	Бог мал	2012	2013	2014	
				2012	2013	2014	2012	2013						2014
Дүн	7 775	6 727	6 582	209	222	300	7 566	6 505	6 282	4.6	95.4	31	43	41

Малжуулах арга хэмжээгээр 0.2 мянган өрхөд 6.6 мянган толгой мал олгогдсон бөгөөд олгосон малын 95.4 хувь нь бог мал, 4.6 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 41 толгой мал ногдож байна.

Малжуулах арга хэмжээнд 2014 онд нийт 462.2 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс 8.2 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, 4.5 хувь нь орон нутгийн хөрөнгө, 87.3 хувь нь бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна.

### ХҮСНЭГТ 5.3. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Үүнээс						Нийт зарцуултанд эзлэх хувь		
	2012	2013	2014	Гадаад орон, ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Орон нутгийн хөрөнгө	Бусад	Гадаад орон, ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Орон нутгийн хөрөнгө	Бусад
Дүн	507 600.4	313 128.0	462 175.0	37 840.0	21 000.0	403 335.0	8.2	4.5	87.3

## **ЗУРГААДУГААР БУЛЭГ**

**ШИНЭЭР ГАРГАСАН БОЛОН ЗАСВАРЛАСАН  
ХУДГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулдаг.

2014 онд 116 худаг шинээр ашиглалтанд орсноос 40.5 хувь буюу 47 худаг нь инженерийн хийцтэй, 59.5 хувь буюу 69 нь энгийн уурхайн худаг байна.

### ХҮСНЭГТ 6.1.1. ШИНЭЭР ГАРГАСАН ХУДГИЙН ТОО

	Шинээр гаргасан худгийн тоо, бүгд				Үүнээс:							
					Инженерийн хийцтэй				Энгийн уурхайн			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014
Дүн	99	62	89	116	32	15	43	47	67	47	46	69

### ХҮСНЭГТ 6.1.2. ШИНЭЭР ХУДАГ ГАРГАХАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ

Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Үүнээс:							
	Улсын төсвийн хөрөнгө		Гадаад орон, ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр		Малчдын өөрсдийн хөрөнгөөр			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Дүн	668 166.7	752 406.3	462 659.9	474 278.8	132 300.3	-	73 206.5	278 127.5

Шинээр худаг гаргахад нийт 752.4 сая төгрөг зарцуулсны 63.0 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 37.0 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

### ХҮСНЭГТ 6.2.1. ЗАСВАРЛАСАН ХУДГИЙН ТОО

Засварласан худгийн тоо, бүгд	Үүнээс:											
					Инженерийн хийцтэй				Энгийн уурхайн			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014
Дүн	138	84	34	152	17	8	8	22	121	76	26	130

2014 онд нийт 152 худаг засварласнаас 14.5 хувь буюу 22 нь инженерийн хийцтэй, 85.5 хувь буюу 130 нь энгийн уурхайн худаг байна.

### ХҮСНЭГТ 6.2.2. ХУДАГ ЗАСВАРЛАХАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ

Худаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Үүнээс:							
	Улсын төсвийн хөрөнгө		Гадаад орон, ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр		Малчдын өөрсдийн хөрөнгөөр			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Дүн	85 279.8	218 470.0	-	164 600.0	65 379.8	3 600.0	19 900.0	50 270.0

Худаг засвар шинэчлэлд нийт 218.5 сая төгрөг зарцуулсны 75.3 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 1.6 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 23.1 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ**

### **ГАЗАР ТАРИАЛАН**

## 7.1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ


Аймгийн хэмжээгээр 2014 онд нийт 5818.7 га-д тариалалт хийсэн нь урьд оныхоос 3.3 дахин нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 7.1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га-гаар

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
							Хувь	Зөрүү
Нийт тариалсан талбай	285.2	261.4	126.7	130.5	435.7	5 818.7	13.4*	5 383.0
Үр тариа	100	80.0	-	-	300.0	2 434.0	8.1*	2 134.0
үүнээс: Буудай	100	80.0	-	-	-	1 766.0	-	-
Төмс	46.7	59.0	67.1	64.5	66.9	75.3	112.6	8.4
Хүнсний ногоо	24.3	28.0	30.2	23.7	25.1	32.2	128.3	7.1
Тэжээлийн ургамал	14.2	94.4	29.4	42.3	38.7	227.2	5.8*	188.5
Техникийн ургамал	-	-	-	-	5.0	3 050.0	610*	3 045.0

Энэ онд төмс 75.3 га-д, хүнсний ногоо 32.2 га-д, тэжээлийн ургамал 227.2 га-д тус тус тариалсан нь урьд оноос үр тариа 2134 га, төмс 8.4 га, хүнсний ногоо 7.1 га, тэжээлийн ургамлын тариалалт 188.5 га, техникийн ургамал 3045 га-аар тус тус өссөн байна.

ЗУРАГ 7.1. ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га



2014 онд тариалсан талбайн бүтцийг авч үзэхэд 41.8 хувийг үр тариа, 1.3 хувийг төмс, 0.6 хувийг хүнсний ногоо, 3.9 хувийг тэжээлийн ургамал, 52.4 хувийг техникийн ургамал тус тус эзлэж байна.


## 7.2. ХУРААСАН УРГАЦ

Манай аймаг 2014 онд 4.0 мянган тн үр тариа, 0.7 мянган тн төмс, 0.4 мянган тн хүнсний ногоо, 0.2 мянган тн тэжээлийн ургамал, 1.4 мянган тн техникийн ургамал хураан авсан нь урьд оныхоос төмс 3.8 тн-оор буюу 0.5 хувиар, хүнсний ногоо 79.3 тн-оор буюу 29.1 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 7.2. ХУРААСАН УРГАЦ, тн-оор

	Хураасан ургац						2014/2013	
	2009	2010	2011	2012	2013	2014	Хувь	Зөрүү
Үр тариа	60.0	40.0	-	-	430.0	3 965.0	9.2*	3 535.0
үүнээс: Буудай	60.0	40.0	-	-	-	3 195.0	-	-
Төмс	366.4	437.4	647.5	683.2	709.8	713.6	100.5	3.8
Хүнсний ногоо	176.0	217.2	212.1	223.1	272.7	352.0	129.1	79.3
Тэжээлийн ургамал	18.8	14.4	53.6	99.8	40.6	207.0	5.1*	166.4
Техникийн ургамал	-	-	-	-	20	1 350.0	67.5*	1 330.0

ЗУРАГ 7.2. ХУРААСАН УРГАЦ, тн



## ДҮГНЭЛТ

Мал тооллогын дүнгээр малын тоо 2014 оны жилийн эцсийн 2.8 сая толгой болж, өмнөх оноос 326.8 мянган толгой буюу 13.1 хувиар өслөө. Малын тоо толгойг өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь өвчин болон байгалийн гамшигт үзэгдэлээр нийт 10.8 мянган толгой том мал хорогдсон хэдий ч, байгаль, цаг уурын тааламжтай нөхцөл бүрдэж, төлөө сайн бойжуулсан нь нөлөөлсөн байна.

2014 оны жилийн эцэст аминдаа малтай 9.3 мянган өрх тоологдсоны 6.6 мянган өрх нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт 13.9 мянган малчид ажиллаж байгаагын 42.7 хувь нь 16-34 насны залуучууд, 51.8 хувь нь 35-аас дээш тэтгэвэрт гарах хүртлэх насныхан, 5.5 хувь нь тэтгэврийн насны хүмүүс эзэлж байгаа бөгөөд нийт малчдын 45.3 хувь эмэгтэйчүүд байна.

Малтай нэг өрхөд дундажаар 300 толгой мал ногдож байгааг таван төрлөөр нь авч үзвэл тэмээ 1, адуу 25, үхэр 21, хонь 147, ямаа 107 байна.

Нийт малчин өрхийн 79.2 хувь нь телевизортой, 43.4 хувь нь авто машинтай, 52.8 хувь нь мотоцикльтой байгаа нь урьд оноос өсчээ. Энэ нь малчидын маань өөрсдийн ажиллаж амьдрах нөхцөлийг илүүтэйгээр анхаардаг болсон нь сайшаалтай зүйл юм.

Мал аж ахуйн салбарын өсөлт нь хүн амын хүнсний хэрэглээнд нийлүүлж байгаа дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах боломжийг бүрдүүлэн, экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийг өсгөн улмаар уг салбарын орлогын хэмжээг нэмэгдүүлэх таатай нөхцөл болж байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа ашиг шим өндөртэй мал үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн авах нь чухал юм.

Эдгээр арга хэмжээг жигдрүүлэхийн тулд малчдын хөдөлмөрийг нэгтгэх, малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах талаар сургалт зохион байгуулах, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, мал сүргийн бүтцийг тэнцвэржүүлэх, мал сүргийг эрсдлээс хамгаалах даатгалын системийг сайн хөгжүүлэх зэрэг арга хэмжээг сайжруулан, иргэд, малчдад хүртээмжтэй болгон хэрэгжүүлэх нь маш чухал байна.

Сүүлийн жилүүдэд малын тоо, толгой өсөхийн хэрээр бэлчээрийн даацын хүрэлцээ маш ихээр муудаж байгаа билээ. Мөн бэлчээрт сөргөөр нөлөөлж байгаа бас нэг зүйл бол ус, худагтай газар хэт олон айл, малаа улирал дамжин бөөгнөрөн нутаглаж, бэлчээрийг талхлан доройтуулж байгаа явдал юм. Иймд бэлчээрийг сэлгэн

ашиглах, отор нүүдлийг зайлшгүй хийдэг болгох хөшүүрэг бүхий механизмийг малчдын дунд бий болгох шаардлагатай.

Бэлчээрийн доройтол нь малын тоо толгойг хязгаартай байлгахыг шаардаж байна. Ялангуяа бэлчээрт халтай ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах, бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь, 1 ямаа гэсэн харьцаагаар өсгөж үржүүлэхэд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

2014 онд 752.4 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр инженерийн болон энгийн хийцтэй 116 худаг гаргаж, 218.5 сая төгрөгөөр 152 худаг засварлаад байна.

Газар тариалангийн салбарт 2014 онд аймгийн хэмжээнд 5.8 мянган га талбайд тариалалт хийж, үүнээсээ үр тариа 4.0 мянган тн, төмс 0.7 мянган тн, хүнсний ногоо 0.4 мянган тн, тэжээлийн ургамал 0.2 мянган тн, техникийн ургамал 1.4 мянган тн-ыг тус тус хураан авсан. Сүүлийн жилүүдэд манай аймагт газар тариалан нилээдгүй хөгжих хандлага ажиглагдаж байна.

Хамгийн гол асуудал бол орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдхүүнийг хадгалах, боловсруулах, борлуулах чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдхүүнийг бэлтгэх төвлөрсөн газрууд, хадгалах, хөргөх агуулах, зоорийг бий болгох нь чухал байна.

## АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

- 2014 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтадын тооллогын дүн
- Сүхбаатар аймгийн Статистикийн эмхэтгэл 2012, 2013 он
- Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эцсийн мэдээ
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сайт /[www.1212.mn/](http://www.1212.mn/)

## ХАВСРАЛТУУД

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Малтай өрх, малчин өрхийн тоо, сумаар.....	33
Хүснэгт 2. Малчдын тоо, насны бүрэлдэхүүн, сумаар.....	33
